

БАТЛАВ:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ У БАЛЖИННЯМ
2023 оны 01 сарын 16 өдөр

ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ 2023 ОНЫ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 01 дүгээр сарын 16

Рашаант

Нэг.Нийтлэг үндэслэл

Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйл, 7.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр тогтоол “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 26-ны өдрийн А/286 дугаарт захирамж болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас, дотоод хяналт шалгалтын талаар гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.

Хоёр.Зорилго

Байгууллагын үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, дээд газрын тогтоол шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, аливаа эрсдэлээс хамгаалах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх, ёс зүйн зөрчил, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хамрах хүрээ	Хүрэх үр дүн
1	2	3	4	5
Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих				
1	Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт Засгийн газрын тогтоол	Сар бүр	Бүх алба	Хамааралтай заалтын хэрэгжилтийг сар тутамд гүйцэтгэлийн мэдээллийн цахим системд оруулж, үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
2	Засгийн газрын мөрийн хөтөлбөр	II, IV улирал	Бүх алба	Хамааралтай арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилээр 70%-с дээш, жилийн эцэст 90%-с дээш хангах, хэрэгжилтийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргасан байна
3	ХХААХҮЯ-ын сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ	II, IV улирал	Бүх алба	38 зүйл заалт хяналтад байгаагаас хэрэгжилтийг хагас жилээр 70%-с дээш, жилийн эцэст 90%-с дээш хангах, хэрэгжилтийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
4	Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө	II, IV улирал	Бүх алба	12 заалт хяналтад байгаагаас хэрэгжилтийг хагас жилээр 70%-с дээш, жилийн эцэст 90%-с дээш хангах,

1	2	3	4	5
				хэрэгжилтийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
5	ИТХ-ын тогтоол, шийдвэр	II, IV улирал	Бүх алба	хяналтад байгаа арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилээр 70%-с дээш, жилийн эцэст 90%-с дээш хангах, хэрэгжилтийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
6	Аймгийн Засаг даргын захирамж	II, IV улирал	Бүх алба	хяналтад байгаа арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилээр 70%-с дээш, жилийн эцэст 90%-с дээш хангах, хэрэгжилтийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
7	Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	II, IV улирал	Бүх алба	хяналтад байгаа арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилээр 70%-с дээш, жилийн эцэст 90%-с дээш хангах, хэрэгжилтийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
8	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	II, IV улирал	Бүх алба	Хэрэгжилтийг бүрэн хангах, үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
9	Албаны хагас жилийн бичмэл тайлан	II улирал	Бүх алба	Албадын хагас жилийн бичмэл тайлантай танилцаж, дүгнэлт хийх
10	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал	II, IV улирал	Бүх алба	Ил тод байдлыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэн зөв үнэлэх
11	ХХААХҮЯам болон аудитаас өгсөн зөвлөмж	IV улирал	Бүх алба	Яамны ХШҮ-ны газраас ирүүлсэн зөвлөмжийг мөрдөн хэрэгжилтийг бүрэн хангасан байна.
12	Үндэсний хөтөлбөрүүд	IV улирал	Хамаара л бүхий алба	Хөтөлбөрүүдийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
13	Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт	II, IV улирал	Хамаара л бүхий алба	Хөтөлбөрүүдийн үнэлгээг зөв тооцох, үнэн зөв, бодитой тооцож гаргана.
Хоёр.Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, дотоод журмын биелэлт				
14	Ажилчдын ажлын байрны хөдөлмөрлөх нөхцөл, эрүүл ахуйн байдалд дүн шинжилгээ хийх,	IV улирал	Бүх алба	Ажиллах тоотой орчинг бүрдүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн байна.
15	Нэгж тус бүрээр ажлын цагийн нэгдсэн хуваарийн дагуу ажил эхлэх, дуусах, үдийн цайны завсарлага цагийн хуваариар явагдаж байгаад хяналт хийх	II, IV улирал	Бүх алба	Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд анхаарах, сэрэмжлүүлэг өгөх
16	Компьютер, техник, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, ашиглалт, эрсдэлийг тооцоолох	II, IV улирал	Нийт албан хаагчид	Техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, эвдрэл гэмтлийг сэргээн засварлах
17	Мэргэжилтнүүдийн ажлын ачаалалд хяналт үнэлгээ өгөх, ажлын тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр асуудал дэвшүүлэх	II, IV улирал	Нийт албан хаагчид	Ажлын ачааллыг тэнцвэржүүлж, жигд ажиллах зарчмыг баримтлах
Гурав. Албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилт				
18	Ёс зүйн зөвлөлийн ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангах	II, IV улирал	Нийт албан хаагчид	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах
19	Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагын	II, IV улирал	Нийт албан хаагчид	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах

1	2	3	4	5
	төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах			
20	Ажлын байрны дарамтгүй орчин бүрдүүлсэн эсэх түүнээс урьдчилан сэргийлэх	II, IV улирал	Нийт албан хаагчид	Ажлын байрны дарамтаас ангид хамт олон болох
21	Иргэдээс ирүүлсэн, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт тавих	II, IV улирал	Нийт албан хаагчид	Өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэж, хариу өгсөн байх
Дөрөв. Шилэн данс, Өмчийн бүртгэлийн тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тавих хяналт шалгалт				
22	Шилэн дансны бүртгэл хөтлөлтийг хянах	Улирал тутам	ЗААА	Шилэн дансны мэдээллийг орхигдуулахгүй байх
23	Эд хөрөнгийн тооллогын комиссын үйл ажиллагаанд хяналт тавих	II, IV улирал	ЗААА	Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, бүрэн бүтэн байдлыг хангуулах
24	Актлах эд хөрөнгийн жагсаалтад хяналт тавих	II, IV улирал	ЗААА	Актлах эд хөрөнгөнд хяналт тавих

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Б.ЦЭРЭНХАНД* Б.ЦЭРЭНХАНД